

## Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд

Н.Дорждарь

### Гол агуулга

- Монгол Улсын Шилэн дансны тухай хууль нь олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын санхүү болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг урьд өмнө байгаагүй түвшинд дэлгэн харуулж байна.
- Таван сая төгрөгөөс дээш (ойролцоогоор 1,750 ам.доллар) үнийн дүн бүхий санхүүгийн гүйлгээ бүрийг тайлагнах хуулийн шаардлага нь тэр бүр ил байгаагүй төрийн өмчит уул уурхайн компаниудын ханган нийлүүлэгч болон худалдан авагчдыг тодорхой харуулж байна.
- Хуулийн дээрх шаардлагын хэрэгжилт сүүлийн хоёр жилийн хугацаанд нэлээдгүй сайжирсан хэдий ч олон томоохон компани өнөөг хүртэл тайлан гаргаагүй, мөн зарим нь мэдээллийг шаардлагатай түвшинд задлан тайлагнахгүй байна.
- Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж хэрэгжүүлснээр төрийн өмчит олборлох компаниудын хариуцлага сайжрахаас гадна Монголд төдийгүй дэлхийн бусад оронд ажиллаж буй уул уурхайн компаниуд энэхүү шинэ стандартыг мөрдөхөд дэмжлэг болно.

## Сэдэл ба түүвэр

2014 онд батлагдсан Монгол Улсын Шилэн дансны тухай хуулиар төрийн өмчийн байгууллага, аж ахуйн нэгжүүд санхүүгийн болон үйл ажиллагааныхаа дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил болгохыг зохицуулсан байдаг. Улмаар Засгийн газрын Шилэн дансны цахим сан үүсэж, төрийн ил тод байдлын төвлөрсөн цэг болоод байна. Гэвч төрийн байгууллага нэгжүүд, түүн дотор Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа төрийн өмчит компаниуд (ТӨК)-ын хувьд хуулийг дагаж мөрдөх байдал харьцангуй жигд бус байна. Хууль ийнхүү хангалттай хэрэгжихгүй байгаа нь нэг талаас хэн заавал тайлагнах тухай тус хуульд нэг мөр заагаагүйтэй холбоотой хэдий ч нөгөө талаас хуулийг хэрэгжүүлэхэд Засгийн газар идэвхгүй, хангалтгүй ажилласантай болон хуулийг мөрдөөгүй этгээдүүдэд хүлээлгэх хариуцлага дутмаг байгаатай холбоотой.

Энэхүү тайланд уул уурхайн гол ТӨК-уудын Шилэн дансны хүрээнд тайлагнаж буй мэдээллийн нэг төрлийг онцгойлон авч үзсэн. Тухайлбал, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш (ойролцоогоор 1,750 ам.доллар) үнийн дүн бүхий бүх гүйлгээг нэг бүрчлэн тайлагнах шаардлагатай холбоотой мэдээлэл юм. Хуульд харьцангуй бага үнийн дүнгээр босго тогтоосон нь тайлан гаргаж буй компаниудын бизнесийн үйл ажиллагаанд нарийвчилсан шинжилгээ хийх боломжийг олгож

байна. Тиймээс энэхүү шинжилгээгээрээ ТӨК-уудын бизнесийн үйл ажиллагааг ойлгоход тустай баримт нотолгоог гаргаж ирэхийн зэрэгцээ өгөгдөл мэдээллийн хэрэглээг хөхиүлэн дэмжихийг хичээсэн болно. Түүнчлэн тайлагналын үйл явцыг задлан авч үзэж, эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг компаниудын хувьд ил тод байдал, олон нийтийн хяналтыг баталгаажуулахын тулд уг үйл явцыг хэрхэн сайжруулах талаар шинжлэв. Улмаар сонирхогч талууд өөрсдийн судалж буй асуултууддаа хариулт авахад нь санаа өгөх зорилгоор өгөгдлийн дүрслэлийн аргыг түлхүү ашиглав.

Хүснэгт 1-т есөн компанийг жагсааж, тэдгээрийн Шилэн дансанд мэдээлсэн нийт гүйлгээний тоо болон үнийн дүнг компани тус бүрийн орлого (орох мөнгөн урсгал), зарлага (гаргах мөнгөн урсгал)-ын гүйлгээгээр ангилан харуулав.

|                |         | Гүйлгээний тоо | Нийт үнийн дүн<br>(сая төгрөг) |
|----------------|---------|----------------|--------------------------------|
| Эрдэнэт        | Орлого  | 3,628          | 6,066,828.5                    |
|                | Зарлага | 8,440          | 5,850,719.2                    |
| Эрдэнэс ТТ     | Орлого  | 1,494          | 3,454,782.1                    |
|                | Зарлага | 540            | 2,825,412.8                    |
| Монрос         | Орлого  | 1,232          | 602,716.2                      |
|                | Зарлага | 3,354          | 386,519.6                      |
| Эрдэнэс Монгол | Орлого  | 5,723          | 531,680.9                      |
|                | Зарлага | 126            | 240,590.7                      |
| Мон-Атом       | Орлого  | 38             | 2,612.0                        |
|                | Зарлага | 63             | 952.1                          |
| Эрдэнэс ОТ     | Зарлага | 153            | 1,008.6                        |
| Эрдэнэс Ассет  | Орлого  | 10             | 720.5                          |
|                | Зарлага | 7              | 47.1                           |
| Эрдэнэс Метан  | Орлого  | 4              | 188.5                          |
|                | Зарлага | 1              | 9.8                            |
| Эрдэнэс Алт    | Зарлага | 20             | 164.1                          |
| <b>НИЙТ</b>    |         | <b>24,833</b>  | <b>19,964,953</b>              |


**Хүснэгт 1. Төрийн өмчит компаниудын шилэн дансны мэдээлэл**

Таван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ


Эрдэнэт болон Эрдэнэс Таван Толгой нь зэсийн баяжмал, металлургийн нүүрс олборлогч, экспортлогч томоохон компаниуд билээ. Монголросцветмет бол жоншны баяжмал болон алт олборлодог дунд хэмжээтэй компани юм. Эрдэнэс Монгол нь холдинг хэлбэртэй компани бөгөөд Эрдэнэт болон Монголросцветметээс бусад энэхүү түүвэрт багтсан компаниудын толгой компани юм. Үлдсэн нь уран, нүүрсний давхаргын метан хий, алт боловсруулалт болон санхүүгийн хөрөнгийн менежментийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр зорьж буй Эрдэнэс Монголын харьяа жижгэвтэр компаниуд билээ. Эдгээр компаниудын 2017 оны эхэн үеэс эхлэн хийгдсэн ойролцоогоор 20 орчим их наяд төгрөгийн үнийн дүн бүхий нийт 24,833 гүйлгээний мэдээлэл Шилэн дансанд бүртгэгдсэн байна. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон компаниудын хувьд тайлагнасан гүйлгээний тоо их байгаа нь ойлгомжтой бол зарим жижиг компаниудын хувьд тайлагнасан гүйлгээний тоо цөөн, үнийн дүн нь бага байгаа нь эдгээр компаниудыг хэт яаран байгуулсан юм биш байгаа гэх эргэлзээ, асуултыг төрүүлж байна.

# Шуурхай ба иж бүрэн байдал

Ашигласан өгөгдөл мэдээлийг 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Засгийн газрын Шилэн дансны цахим хуудаснаас татаж авсан. Зураг 1-д Шилэн дансны портал санд мэдээлэл оруулж эхэлсэн хугацааг компани тус бүрээр харуулав. Хэдийгээр хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэн ч уул уурхайн ТӨК-ууд дөнгөж 2019 оноос эхлэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг тайлагнах болсон байна. Салбарын гол холдинг компани болох Эрдэнэс Монгол болон түүний зарим жижиг охин компаниуд 2020 оны сүүл үеэс л тайлан гаргаж эхэлсэн. Мөн хамгийн сүүлд оруулсан мэдээллийн хугацааг харвал Эрдэнэс Алт болон Эрдэнэс Метан зэрэг компаниуд сүүлийн үеийн мэдээллийг шинэчилж оруулаагүйг харж болно.




Компаниуд хийгдсэн гүйлгээг Шилэн дансанд дунджаар хэдэн өдрийн дотор тайлагнаж байгааг Зураг 2-г үзүүлэв. Ихэнх гүйлгээг нэг сарын дотор тайлагнасан байгаа ч нэг жилээс дээш хугацаагаар хоцорч тайлагнасан олон тооны гүйлгээ мөн байна. Эрдэнэс Таван Толгой зэрэг зарим компани таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг зөвхөн “төрийн өмчийн үйлдвэрийн газар” гэж албан ёсоор бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүдэд хамаарах хуулийн заалт гэж үзээд тайлагнадаггүй байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал Эрдэнэс Таван Толгой нь хувьцаат компани юм. Сангийн яам Шилэн дансны менежерийн хувьд тайлангийн маягыг илүү тодорхой болгосноор Эрдэнэс Таван Толгой зэрэг ТӨК-ууд ийм төрлийн гүйлгээг тайлагнах байдал мэдэгдэхүйц сайжирсан.



**Зураг 2. Шилэн дансанд мэдээлэл оруулсан хугацаа**

Гүйлгээний хийгдсэн өдөр болон мэдээллийг нь нийтэлсэн өдрийн хооронд өнгөрсөн хугацаа, өдрөөр

Анхаарал татсан дараагийн асуудал бол компанийн оруулсан мэдээллийн иж бүрэн байдал юм. Мэдээллийг сар бүр оруулах шаардлага тавигддаг. Зарим компаниуд мэдээлэл огт оруулаагүй (цэнхэр өнгө) бол зарим нь шаардлагатай мэдээллийг оруулсан гэж тайлагнасан ч тухайн сарын тайланг нягтлахад мэдээлэл байхгүй, хоосон (шаргал өнгө) байгааг Зураг 3-т үзүүлэв. Сар тутмын мэдээллийг зохих ёсоор оруулсан гүйлгээний эзлэх хувийн жинг хөх өнгөөр дүрслэв. Үүнээс харахад Эрдэнэс Оюу Толгой, Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэс Метан зэрэг компаниуд их хэмжээний мэдээллийг бүрэн оруулаагүй байна.



**Зураг 3. Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдал**

Таван сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээний сар тутмын тайлагналын иж бүрэн байдал, компани тус бүрээр

Товчхондоо, Шилэн дансны хэрэглээ, мэдээлэл оруулах байдал нь уг судалгаанд хамрагдсан есөн компанийн хувьд харилцан адилгүй байна. Багануурын нүүрсний болон Оюу толгойн зэсийн уурхай зэрэг ямар ч тайлан гаргадаггүй зарим компаниуд ч байна. Эдгээр компаниудын тухайд хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэх тайлбарыг өгдөг. Гэтэл Баганууртай эрх зүйн хувьд яг ижил статустай, Монголын хөрөнгийн бирж дээр цөөнх хувьцаагаа нээлттэй арилждаг Шивээ-Овоо компани гэхэд Шилэн дансыг зохих ёсны дагуу хөтөлж ирсэн. Цөөнх хувьцааг нь Засгийн газар эзэмшдэг Оюу толгой компанийн хувьд улсдаа хамгийн ил тод компани хэмээн мэдэгддэг ч үнэн хэрэгтэй Шилэн дансны тухай хуулийн дагуу ТӨК-ууд тайлагнаж эхэлсэн мөчөөс эхлэн тэднээс хоцорч эхэлсэн байдаг.

Тайлангийн иж бүрэн байдлыг сонирхвол, ямар мэдээллийг оруулах шаардлагатай бөгөөд тэдгээрийг бодитоор оруулсан эсэхийг Хүснэгт 2-г үзүүлэв. ТӨК-ууд гүйлгээний үндэслэл болсон шийдвэрийн хуулбарыг бараг 100 хувь оруулдаггүй, мөн дансны дугаар, тухайн данс бүртгэгдсэн банк болон гүйлгээний утга, тэмдэглэл зэрэг мэдээллийг тэр бүр оруулаагүйг ажиглаж болно. Холбогдох эрх мэдэлтний гаргасан шийдвэрийг мэдээлэх шаардлагыг бүрэн орхигдуулж байгааг бодолцвол хуулийн уг шаардлагыг компаниуд яагаад дагаж мөрдөхгүй байгааг судлах, зайлшгүй гэвэл уг шаардлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

| Оруулах өгөгдөл | Оруулаагүй дүн | Оруулаагүй дүн, хувиар |
|-----------------|----------------|------------------------|
| Шийдвэр         | 24,822         | 99.96                  |
| Дансны дугаар   | 119            | 0.48                   |
| Тэмдэглэл       | 38             | 0.15                   |
| Дансны нэр      | 10             | 0.04                   |
| Огноо           | 2              | 0.01                   |
| Харилцагч       | 1              | 0.00                   |
| Үнийн дүн       | 0              | 0.00                   |


Хүснэгт 2.  
Тайлагнасан  
өгөгдлийн иж бүрэн  
байдал

Нийт өгөгдөл: 24,833


Хуулийн шаардлагыг нэг мөр биелүүлэхгүй байгаа болон өгөгдөл мэдээлэл иж бүрэн биш байгаа нь Сангийн яамны хариуцаж буй өгөгдөл цуглуулах, ил тайлагнах техникийн шийдлүүдтэй зарим талаараа холбоотой. Бодит өгөгдөл байхгүй хэдий ч мэдээллийг оруулсан мэтээр тайлагнах нь компаниуд хуулийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавихад төвөг учруулж байна. Ийм үед наанадаж тодорхой өгөгдөл мэдээллийг тайлагнаагүй тодорхой шалтгааныг компани тайлбарлах хэрэгтэй. Цаашилбал, бүх тайланг сар сараар нь татаж авах боломжтой байгаа бөгөөд өгөгдлийн санг бүхэлд нь татаж авахын тулд олон давталттайгаар хуулах эсхүл техникийн өндөр түвшний кодчилал ашиглах шаардлагатай болдог. Бүрэн бус байдлыг арилгах, хуулийн хэрэгжилтийг сайжруулахын тулд Сангийн яамны зүгээс мэдээллийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр татаж авах хувилбарыг хэрэглэгчдэд олгох нь чухал юм.

## Гүйлгээний мэдээллийн дэлгэрэнгүй

Энэ хэсэгт компаниудын гүйцэтгэлийг судлахад тустай бодит өгөгдөл мэдээллийг нягтлан үзэв. Зураг 4-т гүйлгээ хийгдсэн сар болон (орлого ба зарлагын) гүйлгээний тоо, нийт үнийн дүнг үзүүлэв. Түүвэрт орсон есөн компанийн хувьд тайлангаа 2019 оны эхээр гаргаж эхэлсэн хэдий ч орлогын мэдээлэл нь 2017 оны эхэн үеэс, харин зарлагынх нь 2019 оны эхнээс ил болсон байна. Гүйлгээний нийт үнийн дүн 2020 оны 12 дугаар сард оргил хэмжээндээ хүрсэн бол 2021 оны эхний улиралд огцом буурчээ.




2019 болон 2020 онд орлого нь зарлагаасаа бага дүнтэй байсан бол 2021 онд энэ бэсрэг хандлага эргэснийг Зураг 5-аас харж болно. 2021 онд түүхий эдийн үнэ өссөнөөр ТӨК-уудад таатай нөхцөл үүссэн байх талтай.



Зураг 5. Тайлагнасан гүйлгээний үнийн дүн, жилээр  
Тэрбум төгрөг


Цаашилбал, уг мэдээллийг тодорхой компанийн түвшинд задлан дүрслэв. Монгол Улсын өмнөд хэсэгт орших Тавантолгойн нүүрсний ордын томоохон хэсэгт олборлолт явуулж, бүх бүтээгдэхүүнээ Хятад улсад экспортолдог Эрдэнэс Таван Толгой болон дөч орчим жилийн түүхтэй зэсийн баяжмал үйлдвэрлэгч Эрдэнэт компаниуд бусад компаниудаас хол илүү дүнтэй орлого, зарлагыг тайлагнасанд санамсаргүй зүйл байсангүй. Бусад ТӨК-уудын хувьд холдинг компани болох Эрдэнэс Монгол болон жоншны баяжмал голлон үйлдвэрлэдэг Монголросцветмет нь дээрх компаниудаас бага хэдий ч чамлахааргүй их үнийн дүнтэй гүйлгээг тайлагнасан байна. Бусад таван компанийн хувьд маш бага үнийн дүнтэй гүйлгээг тайлагнасан тул дээрх дөрвөн компаниас салгаж дүрслэхэд хүрсэн бөгөөд эдгээрийг Зураг 6-д харуулав.



Зураг 6. Нийт гүйлгээний үнийн дүн, компаниар

Рио Тинто компанитай түншлэн Оюу Толгой компанийн цөөнх хувьцааг эзэмшдэг Эрдэнэс Оюу Толгой болон алт хайлуулах үйлдвэр барих, мөн алт мөнгөний уурхай эрхлэхийг зорьж буй Эрдэнэс Алт компаниуд Шилэн дансны хүрээнд ямар ч орлогын мэдээлэл тайлагнаагүй байгааг онцлох нь зүйтэй. Харин Францын томоохон компани болох Орано-тай хамтран ураны уурхай барьж буй Мон-Атом, нүүрсний давхаргын метан хийг гаргахыг зорьж буй Эрдэнэс Метан, санхүүгийн хөрөнгийн менежментийн чиглэлээр ажиллахаар төлөвлөж буй Эрдэнэс Ассет зэрэг компаниуд нийт орлогынх нь талаас доогуур хэмжээний зарлагын гүйлгээг тайлагнасан байна.

Эрдэнэт, Эрдэнэс Таван Толгой, Мон-Атом, Эрдэнэс Оюу Толгой зэрэг компаниудын жилээс жилд тайлагнасан гүйлгээний үнийн дүн ихээхэн хэлбэлзэлтэй байсан бол бусад компаниудын хувьд харьцангуй жигд түвшинд байгааг Зураг 7-д дүрслэн харуулав. Эхний хоёр компанийн хувьд энэ хэлбэлзэл нь түүхий эдийн үнийн өсөлт, Ковид-19 цар тахлын үеийн үйлдвэрлэл, экспортын хязгаарлалтаас үүдэлтэй өөрчлөлт байх магадлалтай. Тайлагнасан гүйлгээний ерөнхий дүр зураг ийм байгаа бол тодорхой гүйлгээнүүдийг цааш нарийвчлан судлан шинжилье.



Есөн компанийн тайлагнасан нийт 24,833 гүйлгээний хамгийн том арван гүйлгээг огноо, компани, гүйлгээний төрөл, үнийн дүн, тайлбар тэмдэглэлийн хамт Хүснэгт 3-т үзүүлэв. Сонирхолтой нь эдгээр компаниудын тайлагнасан хамгийн том дүнтэй хоёр гүйлгээ нь Эрдэнэс Таван Толгойн бонд болон банкны зээлээр босгосон санхүүжилттэй холбоотой байна.

2021 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Эрдэнэс Монгол бондын орлогоос орж ирсэн хамгийн их үнийн дүнтэй гүйлгээг тайлагнасан бол маргааш өдөр нь энэ бүх орлогыг зарлагдсан байна. Энэ хоёр гүйлгээ нь Эрдэнэс Монгол болон түүний охин компани хамтран ахмадын тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс төлөхтэй холбоотой санхүүжилтийг гаргасантай хамааралтай байх магадлалтай. Бас нэг анхаарал татсан гүйлгээ бол 2020 оны сүүлийн өдөр Эрдэнэс Таван Толгой компани аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төсөвт урьдчилан төлсөн явдал байв. Он дуусах дөхөхөд гүйлгээ ихээр хийгдэх ийм хандлага байгаа эсэхийг Зураг 8-аас харж болно. 2020 оны сүүлийн сард хийсэн гүйлгээний үнийн дүн мэдэгдэхүйц өссөн нь харагдаж байна. Бусад онуудад энэ хандлага тодорхой ажиглагдахгүй байна.




| Огноо      | Компани        | Төрөл  | Үнийн дүн<br>(сая төгрөг) | Тэмдэглэл                  |
|------------|----------------|--------|---------------------------|----------------------------|
| 2021-04-13 | Эрдэнэс ТТ     | Орлого | 236,161.39                | Бондын орлого              |
| 2020-12-31 | Эрдэнэс ТТ     | Орлого | 230,000.00                | Зээл                       |
| 2021-04-13 | Эрдэнэт        | Орлого | 199,488.08                | Зэсийн орлого              |
| 2021-05-18 | Эрдэнэс Монгол | Орлого | 199,354.49                | Бондын орлого              |
| 2021-05-19 | Эрдэнэс Монгол | Орлого | 199,354.49                | Бондын орлогын зарлага     |
| 2021-08-27 | Эрдэнэс ТТ     | Орлого | 164,199.72                | Бондын орлого              |
| 2020-12-31 | Эрдэнэс ТТ     | Орлого | 152,854.00                | Татварын урьдчилгаа төлбөр |
| 2021-09-15 | Эрдэнэс ТТ     | Орлого | 142,460.97                | Борлуулалтын орлого        |
| 2021-09-28 | Эрдэнэс ТТ     | Орлого | 126,787.98                | Борлуулалтын орлого        |
| 2020-07-02 | Эрдэнэс ТТ     | Орлого | 120,000.00                | Банкны зээл                |

Хүснэгт 3. Хамгийн их үнийн дүнтэй 10 гүйлгээ


### Зураг 8. Гүйлгээний үнийн дүн, сараар

Тухайн жилийн дүнд эзлэх хувь




Үүнтэй адилаар долоо хоногийн аль өдөр гүйлгээ их хийгддэгийг харж болно. Зураг 9-өөс гүйлгээний тоо долоо хоногийн сүүлээр нэмэгдэж байгааг ажиглаж болно. Мөн нийт гүйлгээний 2.1 хувь нь амралтын өдөр хийгдсэн байна. Энэ нь мэдээж тайлагнах явцад гарсан энгийн алдаа байж болох ч Шилэн дансны өгөгдлөөс үүнийг тодорхойлох боломжгүй байна.

Цаашлаад гүйлгээнүүдийн нарийвчилсан мэдээллийг задлан авч үзэх бөгөөд эдгээр уул уурхайн ТӨК-уудын харилцагчдын мэдээллийг эхэлж сонирхье. Эхний ээлжид ТӨК-уудын гүйлгээнүүдийг хийж буй банкнууд, дараа нь тэдний хэнтэй гүйлгээ хийж байгааг авч үзнэ.



Зураг 9. Гүйлгээний хувьчилсан тоо  
Долоо хоногийн гарагаар


ТӨК-уудад үйлчилгээ үзүүлж буй тэргүүлэх банк нь Голомт болон Худалдаа хөгжлийн банк гэдгийг Зураг 10-с харж болно. Мөн зарим гүйлгээг Хаан банк, Хас банк, Төрийн банк болон Улаанбаатар банкаар дамжуулан хийдэг байна. Монголросцветмет ихэвчлэн Хас банкаар үйлчлүүлдэг бол эдгээр ТӨК-уудаас Төрийн банк зөвхөн Эрдэнэт үйлдвэртэй холбоотой байгаа нь сонирхол татаж байна. Төрийн банк нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа цор ганц төрийн өмчит арилжааны банк гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.



Зураг 10. Төрийн өмчит уул уурхайн компаниудын үйлчлүүлдэг банк  
Урсгалуудын өргөн нь гүйлгээний үнийн дүнг илэрхийлнэ.


Мөн уул уурхайн компаниудын зардлын гүйлгээг ямар компани, хувь хүн эцэстээ хүлээн авч буйг нарийвчлан судалж болно. Шилэн дансанд тайлагнасан харилцагчийн нэрсийг цэгцлэн цэвэрлэх нь өгөгдөлтэй ажиллах хэрэглэгчийн хувьд хамгийн том сорилт болж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Учир нь нэг компанийн нэрийг олон янзаар бичиж, компанийн регистрийн дугаар гэх мэт давтагдахгүй өгөгдлийг ил тайлагнахгүй байгаа нь харилцагч тус бүрээр дүн шинжилгээ хийхэд бэрхшээл учруулж байв. Тиймээс өгөгдлийн энэ хэсгийн шинжилгээнд асуудал байхыг үгүйсгэхгүй бөгөөд компаниуд өөрсдийн нэр эсхүл бизнесийн регистрийн дугаарыг зөв оруулах, мөн хувь хүний нэрсийг жигд тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Засгийн газар тайлангийн маягтаа сайжруулах шаардлагатай байна.

Уул уурхайн ТӨК-уудын Шилэн дансанд тайлагнасан гүйлгээг үнийн дүнгээр нь эрэмбэлэн хамгийн их дүнтэй 15 харилцагчийг Зураг 11-т харуулав. Хамгийн их ашиг хүртэгч нь төрийн сан байгаа нь санамсаргүй хэрэг биш бөгөөд төрийн сангийнхтай нэгтгэн авч үзэж болох, гэхдээ тусдаа тайлагнаж буй татварын алба болон Сангийн яамны хүлээн авсан гүйлгээ ч хамгийн их дүнтэй 15 харилцагчийн жагсаалтад багтаж байна. Цаашилбал, дараагийн том дөрвөн харилцагч нь (Таурус, Миллифорд, Оүшин партнерс ба Кинг файне) түүхий эдийн мэргэшсэн арилжаалагчид (трейдер) байх магадлалтай. Рэд металл болон Самсунг корпорац ч мөн адил түүхий эдийн арилжаагчид байх магадлалтай бөгөөд Самсунгийн хувьд уул уурхайд шаардлагатай бусад үйлчилгээг мөн үзүүлдэг гэх мэдээ байдаг. Судалгааны түүвэрт орсон есөн компанийн нэг болох Эрдэнэс Таван Толгой нь их хэмжээний мөнгө хүлээн авагч харилцагчийн нэг байгаа нь сонирхол татаж байна. Энэ нь магадгүй харилцагчийн мэдээллийг буруу оруулж компанийнхаа нэрийг бичсэн байх, эсхүл ТӨК-уудын компани хоорондын зээл болон хараат компаниудын төлбөрийн гүйлгээ байж болох ч өгөгдсөн мэдээллээс үүнийг тогтоох боломжгүй байна.



Зураг 11. Уул уурхайн ТӨК-уудын хамгийн том харилцагчид  
Гүйлгээний нийт үнийн дүнгээр

Зураг 12-т компаниудын тайлангийн гүйлгээний утга хэсэгт хамгийн их тааралдсан үгсийг тоймлон харуулав. Энэхүү хэсэг нь гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулж, тухайн шилжүүлгийн зорилго болон орлого зарлагын ангиллыг нягтлах боломжийг олгох учиртай. Гэвч компаниуд гүйлгээний ангиллыг хийхдээ мөрдөх тодорхой стандарт маягт байдаггүй, тэр байтугай тухайн нэг компанийн хувьд ч тогтсон стандартгүйн улмаас гүйлгээг нарийвчлан судлахад бэрхшээлтэй байна. Ерөнхийдөө “төлбөр”, “зам”, “орлого”, “тэрээ”, “шимтгэл” гэсэн үг хамгийн их ашиглагдсан байна. Ирээдүйд Шилэн дансны өгөгдөл оруулах маягтын гүйлгээний тухай тэмдэглэл тайлбарыг стандартчилах замаар сайжруулах шаардлагатай.




Зураг 12. Тэмдэглэл хэсэгт их орсон үг, компаниар

Өнгө нь компаниудын тайлангуудад хэрэглэгдсэн ижил үгнүүдийг илтгэнэ

## Төрийн байгууллага, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгчдэд төлөх төлбөр


Энэ хэсэгт ТӨК-уудын тайлагнасан зарлагын мэдээллийг дэлгэрүүлэн авч үзэв. Шилэн данснаас гүйлгээний үнийн дүнг олж мэдэхэд хялбар боловч тэдгээрийн зориулалт, хүлээн авагч тэр бүр тодорхой биш байгаа нь компанийн нэр болон гүйлгээний төрлийн тухай мэдээллийг оруулах стандарт маягт байхгүйтэй холбоотойг тэмдэглэх нь зүйтэй. Улмаар гүйлгээний мэдээллийг ангилал үүсгэн тодорхой бүлэгт хуваасан болно.

Зураг 13-т гүйлгээний тоог харилцагчийн бүлгээр харуулав. Хамгийн олон тооны буюу бусад бүлэгтэй харьцуулахад хавьгүй олон зардлын гүйлгээг дотоодын хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд хүлээн авсан байсан тул тэдгээрийн тоог үзүүлээгүй (ихэнх аж ахуйн нэгжүүд хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр бүртгэлтэй байдаг). Дараагийн хамгийн том бүлэг нь гаалийн байгууллага буюу түүнд төлөх гаалийн татвар болон хураамж юм. Мөн компаниуд боловсролын болон сургалтын байгууллагуудад олон тооны төлбөр төлж байгаа нь ажилтнуудаа сургах, давтан сургахтай холбоотой төлбөр байх. Түүнчлэн тодорхой бараа, үйлчилгээ худалдан авсны төлбөр эсхүл мөнгөн дэмжлэг хэлбэрээр хувь хүмүүс (хуулийн этгээд биш)-г чиглэсэн олон тооны төлбөр хийдэг байна. Бусад томоохон зардалд Хятад улсын компаниудад төлөх төлбөр, зам болон нийгмийн даатгалын шимтгэл зэрэг багтаж байна. Гүйлгээний тооны талаарх энэхүү өгөгдөл нь гүйлгээний үнийн дүнг судлахгүйгээр бүрэн гүйцэт биш тул энэ асуудал руу анхаарлаа хандуулья.




Зураг 13. Зарлагын гүйлгээний нийт тоо  
Жагсаалтыг тэргүүлэх ангилал болох дотоодын ХХК-г хассан, хамгийн их дүнтэй 15 харилцагчийн төрөл

Зураг 14-т түүвэрт орсон компаниудын зарлагын хамгийн том 15 хүлээн авагчийг гүйлгээний үнийн дүнгээр харуулав. Дотоодын хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд эдгээр есөн ТӨК-уудын гаргасан зардлын хамгийн том хэсгийг хүлээн авсан байна. Мөн зардлын ихэнх нь компаниудын төрийн өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг, цахилгаан, нийтлэг үйлчилгээ зэрэг төрийн өмчийн байгууллагуудын үзүүлсэн үйлчилгээний төлбөр эсхүл төмөр зам эзэмшигчтэй холбоотой гарсан зардлууд байна. Хятад улсын компаниудад төлөх туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгчийн үйлчилгээний төлбөр нь хил дамнасан хамгийн том зардал болж байна. Хаан болон Голомт банк нь зардлын гүйлгээний хамгийн том хүлээн авагчдын тоонд багтжээ.



Мөн ТӨК-уудын зардлыг тодорхой ямар компани, агентлаг хүлээн авч байгааг харж болно. Зураг 15-т гүйлгээний үнийн дүнг тэгш өнцөгтийн хэмжээгээр, харин хүлээн авагч бүрийг өнгөөр ялган харуулсан ерөнхий дүр зургийг үзүүлэв. Таван компанийн гүйлгээний үнийн дүн хэт бага байгаагаас эдгээр компаниудын зарлагын гүйлгээг уг дүрслэлд харуулах боломжгүй байсныг тэмдэглэе.



Зураг 15. ТӨК-үүдийн зарлагын гүйлгээний үнийн дүн

Тэгш өнцөгт болгон нэг харилцагч


Дээрх зурагт Эрдэнэс Монгол компанийн зардлын ихэнх нь нэг харилцагчид очсон байгаа бөгөөд энэ харилцагч хэн болохыг нягталж болно. Өгөгдлийг шалгаж үзэхэд зарим гүйлгээг зохих ёсоор оруулаагүй байгааг Хүснэгт 4-өөс харж болох ба боловсруулаагүй өгөгдлийн ‘тэмдэглэл’ зэрэг бусад баганаас нэмэлт мэдээлэл авах боломжгүй байв. Шилэн дансанд өгөгдөл оруулах үйл явц нь өгөгдлийг хянах, өгөгдлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд гол асуудал болж байгааг дахин дурдах нь зүйтэй бөгөөд гол ТӨК-уудын төлбөрийн томоохон хэсэг хэнд төлөгдөж байгаа нь тодорхойгүй байгаа нь анхаарал татаж байна.

| Огноо      | Харилцагч      | Компани        | Гүйлгээний дүн (төгрөг) |
|------------|----------------|----------------|-------------------------|
| 2021-05-12 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 1,030,000,000           |
| 2021-05-12 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 1,597,210,368           |
| 2021-05-19 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 199,354,494,272         |
| 2021-05-24 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 16,140,215,176          |
| 2021-04-09 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 276,934,518             |
| 2021-04-09 | Эрдэнэс Монгол | Эрдэнэс Монгол | 2,400,000,000           |

Хүснэгт 4. Эрдэнэс Монгол компанийн зарлагын зарим гүйлгээ

Анхны өгөгдөлд оруулсан байдлаар

Зардлыг нягтлах сүүлчийн алхам болгон ТӨК-уудын хамгийн өндөр дүнтэй зардал, тэдгээр зардлыг хүлээн авч буй үйлчилгээ үзүүлэгч болон ханган нийлүүлэгчдийг харуулав. Зураг 16-аас харахад ТӨК-уудын хамгийн өндөр дүнтэй гүйлгээг хүлээн авагчид нь Сангийн яам, татварын алба болон нүүрсний томоохон уурхайн бүс нутгаас Хятадын хил хүртэлх нүүрс тээвэрлэх төмөр зам барьж буй Монголын төмөр зам, мөн Зүүнбаянгийн төмөр зам байна. Эдгээр төмөр замын төслүүдийг төсөв хэлэлцэх горимоор бус, ТӨК-ууд шууд санхүүжүүлж байгаа нь анхаарал татаж буйг тэмдэглэх нь зүйтэй. Эрдэнэс Таван Толгой компанийн хувьд Титиживисиөү болон Хишиг Арвин компаниуд тус уурхайн хамгийн том хоёр оператор юм. Эрдэнэт компанийн хувьд хамгийн өндөр дүнтэй төлбөрт цахилгааны төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэл багтаж байна.



Зураг 16. Хамгийн өндөр дүнтэй 20 гүйлгээг хүлээн авагчид


Компанийн нэр, гүйлгээний дүн (төгрөг)



## ТӨК-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчид


Энэ хэсэгт ТӨК-уудын орлого талыг судалъя. Эрдэнэс Монгол орлогоо 2017 оноос эхлэн тайлагнасан бол бусад компаниуд 2019 оноос эхэлсэн байна. Түүхий эдийн арилжаалагчдын мэдээлэл өнөөг хүртэл бүрхэг явж ирсэн бөгөөд уул уурхайн томоохон компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчдын талаарх мэдээлэл анх удаа Шилэн дансны мэдээллээр дамжин ил тод болж буйг онцлон тэмдэглэе.

Зураг 17-д компаниудын тайлагнасан орлогыг жил бүрээр ангилан үзүүлсэн ба өмнөх жилээс өссөн эсхүл буурсан байдлыг өнгөөр ялган илэрхийлэв. Эрдэнэт, Эрдэнэс Таван Толгой, Монголросцветмет зэрэг гурван компани хамгийн өндөр үнийн дүн бүхий орлогыг тайлагнасан байна. Эрдэнэс Таван Толгой компанийн орлогын хэмжээ бараг өөрчлөгдөөгүй бол Эрдэнэт, Монголросцветмет-ийн орлого мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Нүүрс экспортлогч Эрдэнэс Таван Толгой компанийн Хятад руу гаргах экспорт цар тахлын улмаас сүүлийн хоёр жилд уналтад орсон бол Эрдэнэт, Монголросцветмет компаниуд үйлдвэрлэлийн хэмжээгээ хадгалж, зэс болон жоншны баяжмалын үнийн өндөр өсөлтөөс хожсон.




Зураг 17. Тайлагнасан орлого, компани болон оноор  
Эрдэнэс Метанаас бусад компани

Зураг 18-д ТӨК-тэй хамгийн олон тооны гүйлгээ хийсэн харилцагчийн төрлийг харуулсан. Дотоодын компаниуд хамгийн олон тооны гүйлгээг хийсэн байгаад гайхах зүйлгүй. Мөн бусад төрийн өмчит компаниудтай бизнес хийх нь нэлээд түгээмэл байна. Гадаадын харилцагчдын жагсаалтыг Хятад, Хонгконг болон Орос компаниуд тэргүүлж байна. Сонирхолтой нь ТӨК-ууд сургалтын үйлчилгээ үзүүлсэн эсхүл сургалтын зардлын нөхөн төлбөрт нэлээдгүй төлбөрийг авдаг байна. Нийгмийн даатгалын байгууллага хамгийн олон тооны гүйлгээ хийсэн 10 харилцагчийн тоонд багтсан нь нийгмийн даатгалын шимтгэл, нөхөн олговортой холбоотой.




Зураг 18. ТӨК-тэй хамгийн олон тооны гүйлгээ хийсэн харилцагчийн 10 төрөл  
Нийт 11,175 орлогын гүйлгээ

Дараагийн дүрслэл болох Зураг 19-д ТӨК-уудад орлого оруулж буй харилцагчийн тоог үзүүлэв. Эрдэнэс Монгол орлого оруулдаг хамгийн олон тооны харилцагчтай бол Эрдэнэс Метан нэг харилцагч буюу толгой компани болох Эрдэнэс Монголоос орж ирсэн дөрвөн удаагийн орлогын гүйлгээг тайлагнасан байна. Эрдэнэс Ассет, Мон-Атом компаниудын хувьд орлого оруулдаг зөвхөн хоёр харилцагч байна. Эдгээр жижиг компаниуд орлогын олон эх үүсвэргүй байгаа нь Эрдэнэс Монгол компанийн удирдлагуудын анхаарах ёстой асуудал юм. Эрдэнэс Монгол, Монголросцветмет компаниуд Эрдэнэт болон Эрдэнэс Таван Толгой компаниудтай харьцуулахад бага орлого олсон хэдий ч эдгээр хоёр компаниас их харилцагчтай байсан байна.



Зураг 19. Орлого оруулагч харилцагчийн тоо  
Нийт 915 харилцагч

Дараагийн ээлжид эдгээр уул уурхайн компаниудын орлогыг төвлөрүүлдэг тодорхой компани, хувь хүмүүсийн талаар дэлгэрүүлэн авч үзэв. Зураг 20-д эдгээр есөн ТӨК-уудын хувьд хамгийн өндөр дүнтэй орлого төвлөрүүлсэн 20 компанийг үзүүлэв. Эрдэнэтийн харилцагч компаниуд хэмжээний хувьд хамгийн томд тооцогдох бөгөөд эдгээр компаниуд ихэвчлэн тус компаниас зэсийн баяжмал худалдан авдаг түүхий эдийн арилжаалагчид байна. Эрдэнэс Таван Толгойн орлогыг ихэвчлэн Хятад улсын компаниуд төвлөрүүлж байгаа бөгөөд Шилэн данснаас нь харвал Эрдэнэс Таван Толгой компани өөрөө 92 тэрбум орчим төгрөгийн гүйлгээний орлогыг төвлөрүүлэгч болсон байна. Эрдэнэс Монгол компанийн хувьд ахмадын тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг чөлөөлөх тухай хуулийг санхүүжүүлэхэд зарцуулах 218 тэрбум төгрөгийн төлбөрийг өөрийн охин компани болох Эрдэнэс Силверээс хүлээн авсан байгаа нь ТӨК-уудын үндсэн бизнесийн үйл ажиллагаанд хамааралгүй ийм хэлцэл нь ашигт ажиллагааг алдагдуулж, хохирол учруулах уу гэдэг асуултыг хөндөнө.



Зураг 20. Хамгийн өндөр дүнтэй орлого төвлөрүүлэгч 20 компани  
Компанийн нэр, гүйлгээний дүн (төгрөг)

## Гол дүгнэлт болон зөвлөмж

Өгөгдлийн гүнд орсон энэхүү судалгааны дүнд дараах гол ажиглалтуудыг хийж байна.

- Монгол Улсын Шилэн дансны мэдээллийн сан нь төр засгаас хийж буй шинэлэг, өргөн цар хүрээтэй ажил бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд бүх оролцогч талуудад мэдээлэл дүн шинжилгээ хийх, шинэчлэлийн санаа сэдэл төрүүлэх, төрийн байгууллагуудад хяналт тавих боломжийг олгоно. Энэ бүх ажил нь засгийн газрын гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулах өндөр магадлалтай.
- Шилэн дансыг төсвийн байгууллагаас гадна ТӨК-ууд хэрэгжүүлж байгаа нь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг, тэр дотроо уул уурхай болон уул уурхайтай холбоотой салбарын олон тооны ТӨК-ууд оршин байгаа өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой.
- Шилэн дансны мэдээлэл нь төр засгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн гол эх сурвалж болж, иргэний нийгэм болон бусад идэвхтэй талууд тодорхой байгууллага болон ТӨК-уудын үйл ажиллагаанд хяналт тавихад уг мэдээллийг идэвхтэй ашиглаж байна. Мэдээллийг идэвхтэй ашигласнаар нийтийн хөрөнгийг буруу зарцуулсан тодорхой тохиолдлууд ил болж, цаашлаад Шилэн дансыг хэрхэн сайжруулах талаар хэлэлцүүлэг өрнөсөн. Шилэн дансны мэдээллийг нэн ялангуяа хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн төлөөллүүд тогтмол шинжлэх, хянах явдал нэмэгдэж, мэргэшиж буйг тэмдэглэх нь зүйтэй.
- Эдгээр ахиц дэвшлийг тэмдэглэхийн сацуу ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэдээлэл, нотолгоо баримтад суурилсан хариуцлагын тогтолцоо, бодлогын шинэчлэлийг нэвтрүүлэх олон боломж нээлттэй хэвээр байна. Боломж ийнхүү алдагдаж байгаа нь зарим талаараа Шилэн дансны мэдээлэл оруулах, мэдээлэл тайлагнах зэрэг өнөөгийн тогтсон үйл явцтай холбоотой ч нөгөө талаараа ил болсон мэдээллийн чанар, ялангуяа тухайн мэдээллийн иж бүрэн, цогц байдалтай холбоотой. Тухайлбал, дараах дутагдлуудыг харьцангуй бага өртөгтэйгөөр засах боломжтой:
  - Шилэн дансны тухай хуулийн хүрээнд тайланг хэн гаргах нь зарим талаараа тодорхой бус байгаагаас үүдэн ТӨК-уудын тайлагнал жигд бус байна. ТӨК-ууд өөр өөр хэлбэрээр бүртгэлтэй байгаа бөгөөд төрийн өмчийн оролцоо компани бүрд харилцан адилгүй байна. Төрийн хувь оролцоотой ч Шилэн дансны хүрээнд тайлан гаргадаггүй томоохон компаниуд бол Багануурын нүүрсний болон Оюу Толгойн зэсийн уурхай юм. Багануурын хувьд ихэнх хувийг төр эзэмшдэг бөгөөд хөрөнгийн бирж дээр хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг ч гүйлгээний талаарх мэдээллээ тайлагнадаггүй. Гэтэл ижил төстэй Шивээ-Овоо компанийн хувьд хуулийг зохих журмын дагуу хэрэгжүүлдэг. Засгийн газар Оюу Толгойн 34 хувийг л эзэмшдэг бөгөөд Рио Тинто компанитай шууд бусаар түншилдэг. Энэ төсөл нь Монголын хувьд олон талаараа чухал ач холбогдолтой. Рио Тинто компанийн хувьд Монгол болон бусад улс орнуудад ил тод байдлаараа манлайлахыг эрмэлздэг ч Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэн ТӨК-уудаас хоцорч байна.
  - Өгөгдлийг цаг тухай бүр тогтмол мэдээлж байх нь ач холбогдолтой. Зарим компаниуд тайлангаа хэдэн жилээр тайлагнаагүй бол зарим компанийн сүүлийн үеийн мэдээлэл байхгүй байна.
  - Өгөгдлийн үнэн зөв байдал чухал бөгөөд өгөгдөл оруулах үйл явцыг сайжруулах шаардлагатай байна. Өгөгдлийн стандарт ангилал, бүлэглэл байхгүй бөгөөд тайланд тайлбар тэмдэглэл гэх мэт чухал өгөгдлийг хялбархан дүн шинжилгээ хийх боломжтой хэлбэрээр тусгахгүй байна.

- Өгөгдөл мэдээллийг хүлээн авах нь ялангуяа компьютерын өндөр ур чадваргүй иргэд болон сонирхсон талуудад бэрхшээлтэй хэвээр байна. Ил мэдээлэл нь тэр бүр компьютерт шууд уншуулах хэлбэрээр байхгүй байгаа бөгөөд дүн шинжилгээ хийх зорилгоор хялбархан татаж авах боломжгүй байна.
- Гүйлгээний өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд зарим чухал мэдээлэл дутуу байсан. Тухайлбал, Шилэн дансны хуулийн хүрээнд гүйлгээ бүрд холбогдох шийдвэрийн мэдээллийн хэсгийг бараг бүгд огоордоггүй байна.
- Шилэн дансны санд мэдээг дүрсжүүлэн, хураангуй байдлаар тайлагнах явдал дутмаг байгаа нь энгийн хүмүүст өгөгдлийг хайх, ойлгоход хүндрэл учруулж байна.

Холбогдох байгууллагуудад чиглэсэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

- **Монгол Улсын Их Хурал** төр засгийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цаашид ч манлайлан ажиллах шаардлагатай байна. Шилэн дансны хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох, ялангуяа төрийн албан хаагчид хуулийн хэрэгжилтийг хангах явдлыг баталгаажуулах, үүнд тайланг үнэн зөв, цаг тухайд нь гаргах, тайланг албан хаагчдын ажлын үнэлгээтэй холбох, мөн тайлангийн аудитыг тогтмол, иж бүрэн хийдэг байх ёстой. Түүнчлэн хэмжээ, төрийн оролцооны хувь, албан ёсоор бүртгүүлсэн хэлбэр зэргээс үл хамааран бүх төрийн өмчит аж ахуйн нэгж тайлан гаргах явдлыг эрх зүйн хүрээнд шийдэх шаардлагатай. Бүх мэдээллийг нээлттэй өгөгдлийн форматаар, тухайлбал компьютерт шууд уншуулах боломжтой, мөн ямар ч зорилгоор дахин ашиглаж болохуйц нээлттэй лицензтэй байхаар хуулийн хүрээнд зохицуулах шаардлагатай.
- Шилэн дансыг хариуцагчийн хувьд **Сангийн яам** цахим санд нэмэлт хөрөнгө оруулалт хийж өгөгдлийн тайлагнал, хандалтыг хялбаршуулан, хэрэглэгчдэд дөхөм болгох замаар мэдээллийн хадгалалт шинэчлэлийг сайжруулах шаардлагатай. Ихэнх өгөгдлийг тусгай маягтаар дамжуулан стандартчилсан байдлаар хүлээн авч байх шаардлагатай. Өгөгдлийг олон төрөл хэлбэрээр татаж авах боломжтой болгох ёстой бөгөөд өгөгдлийн хураангуй тайланг сонирхсон талуудын янз бүрийн хэрэгцээнд нийцүүлэн дүрсжүүлж, дэлгэрүүлж гаргах шаардлагатай.
- **Үндэсний Аудитын Газар** Шилэн дансанд хийх аудитаа сайжруулах, ялангуяа тайлангийн бүрэн бүтэн байдал, цаг тухайд нь тайлагнаж байгаа эсэх, өгөгдлийн үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарах ёстой. Ингэхдээ төрийн аудитын байгууллагын хувьд олон нийт болон иргэний нийгмийн байгууллагуудыг тогтмол мэдээллээр хангаж, өмнө өгсөн зөвлөмжийг тухайн байгууллага хэрэгжүүлж байгаа эсэхийг давхар тайлагнах ёстой.
- **Салбарын төлөөллүүд болон ТӨК-ууд** Шилэн дансыг идэвхтэй сурталчилж, тайлагналыг дотоод ажлын горимдоо тусгах, компанийн болон удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээнд нэвтрүүлэх зэргээр үлгэр жишээ үзүүлэх хэрэгтэй. Мөн өгөгдөл мэдээлэл оруулах үйл явцыг хэрхэн сайжруулах, чанарыг хэрхэн хангах талаар Засгийн газарт зөвлөмж өгч байх хэрэгтэй.

Төгсгөлд нь Монгол Улсын хэрэгжүүлж буй Шилэн данс нь зөвхөн Монголын төдийгүй дэлхийн ТӨК-уудын ил тод байдлын стандарт болох боломжтойг тэмдэглэж байна. Энэхүү тайлан нь бусад орнуудын эдийн засагт нь чухал үүрэг гүйцэтгэдэг олборлох салбарын ТӨК-уудын ил тод байдлыг сайжруулахад санаа сэдэл өгөх болно гэдэгт итгэж байна.

## ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Намхайжанцангийн Дорждарь нь Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол дахь менежерээр ажилладаг.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн нь бодлогын судалгаа хийх, чадавх хөгжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг дэмжих замаар тухайн улс орны иргэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн баялгийнхаа үр шимийг хүртэхэд туслалцаа үзүүлдэг олон улсын хараат бус, ашгийн бус байгууллага юм. Нэмэлт мэдээллийг [www.resourcegovernance.org](http://www.resourcegovernance.org) вэбсайтаас авна уу.

